



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

Аудитын код: САГ-2021/10/СТА-ТЭЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2021 он</p>	<p>Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор: Я.Самбууням Утас: 260949 Цахим хаяг: Sambuunyamyamya@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ц.Хосжаргал Утас: 261628 Цахим хаяг: Khosjargalts@audit.gov.mn</p> <p>Аудитор: С.Бат-эрдэнэ Утас: 260512 Цахим хаяг: Baterdenes@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал	16
3.4 Материаллаг байдал.....	16
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	16
3.5.1 Мөнгөн хөрөнгө.....	16
3.5.2 Авлага	17
3.5.3 Урьдчилгаа	18
3.5.4 Бараа материал	18
3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө	19
3.5.6 Үндсэн хөрөнгө	19
3.5.7 Өр төлбөр	20
3.5.8 Засгийн газрын хувь оролцоо	21
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	21
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	24
3.8 Аудитын гол асуудал.....	24
3.9 Шилэн дансны мэдээлэл	25
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	25
3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал	25
4. Аудитын илрүүлэлт	26
Залруулсан алдаа.....	27
Албан шаардлага	27
5. Менежментийн захидал.....	28
6 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	30
6. Төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт	36

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ПТК	Политехник коллеж
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
УУЭХ	Уул уурхай эрчим хүчний
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХХҮХ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХБХСЗХТ	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ГИШҮҮН, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД А.АРИУНЗАЯА
ТАНАА

2021.04.26 № 1323
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 31,301.6 сая төгрөгийн залруулаагүй алдаа зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнийг давж, УСНББОУС болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал”, “Эрх ба үүрэг”, “Тохиолдсон байх”, “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Тухайлбал:

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайланд насжилт өндөртэй, эргэн төлөлт удааширсан 20,350.3 сая төгрөгийн зээлийн авлагатай, 987.5 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, санхүүгийн тайланд авлагын үлдэгдэл 1,403.6 сая төгрөгөөр илүү бүртгэгдсэн;
- Харьяа 26 байгууллагын санхүүгийн тайланд нэг жилээс дээш насжилттай ажиллагсадтай холбогдсон 49.6 сая, байгууллагаас авах 285.7 сая, төлбөртэй үйлчилгээний 191.2 сая, хувь хүмүүсээс авах 368.0 сая төгрөгийн нийт 894.5 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй зэрэг болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д.ЗАНДАНБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	249,147,935.5	248,150,917.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	7,609,223.5	3,078,893.2
33	АВЛАГА	190,328,117.7	195,421,164.1
34	УРЬДЧИЛГАА	522,572.8	742,043.4
35	БАРАА МАТЕРИАЛ	14,946,170.6	17,024,110.2
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	35,741,850.9	31,884,707.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	289,191,463.3	300,340,368.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	289,191,463.3	300,340,368.1
39200	Биет хөрөнгө	253,867,715.5	261,682,145.3
39300	Биет бус хөрөнгө	35,323,747.7	38,658,222.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	538,339,398.8	548,491,285.9
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	36,595,084.0	45,609,302.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	28,371,772.8	29,626,855.3
41200	Богино хугацаат зээлийн өглөг	7,715.2	1,612,130.2
41300	Өглөг	5,899,244.6	9,464,093.3
41400	Урьдчилж орсон орлого	22,464,813.1	18,550,631.8
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,223,311.1	15,982,447.0
42200	Урт хугацаат зээл	8,223,311.1	15,982,447.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	501,744,314.8	502,881,983.6
51	Засгийн газрын хувь оролцоо	501,744,314.8	502,881,983.6
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	117,562,460.8	124,234,886.5
51200	Хуримтлагдсан үр дүн	266,337,290.7	260,560,170.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	117,844,563.3	118,086,926.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	538,339,398.8	548,491,285.9

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,623,500,841.6	2,412,519,052.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	94,312,287.6	124,315,707.2
120	Нийтлэг татварын бус орлого	94,312,287.6	124,315,707.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,529,188,554.0	2,288,203,344.9
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,574,601,435.4	2,403,683,384.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,574,601,435.4	2,403,683,384.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	136,835,630.9	146,711,105.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	61,412,137.7	74,284,564.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,676,014.2	9,447,497.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,009,774.3	12,282,890.3
2104	Хангамж, бараа материалын зардал	4,335,215.5	4,413,468.7
2105	Нормативт зардал	6,963,624.0	5,542,253.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,875,817.8	1,370,331.4
2107	Томилолт, зочны зардал	930,250.7	223,403.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,415,620.4	8,084,641.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,217,176.3	31,062,055.9
211	ХҮҮ	182.5	1,203.8
212	ТАТААС	605,492,793.3	399,417,600.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	832,272,828.7	1,857,553,475.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	48,899,406.2	8,835,667.2
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	14,969.3	66,112.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	16,565,050.6	11,041,189.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	32,349,324.9	-2,139,410.3

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	461,654,038.8	461,654,038.8
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	6,679,116.4	6,679,116.4
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	468,333,155.3	468,333,155.3
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-323,681.4	-323,681.4
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,385,516.0	1,385,516.0
Тайлант үеийн үр дүн	32,349,324.9	32,349,324.9
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	501,744,314.8	501,744,314.8
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	860,858.7	860,858.7
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	502,605,173.5	502,605,173.5
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	2,416,220.3	2,416,220.3
Тайлант үеийн үр дүн	-2,139,410.3	-2,139,410.3
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	502,881,983.6	502,881,983.6

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,692,916,535.8	2,507,472,803.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	129,874,600.5	203,764,372.6
120	Нийтлэг татварын бус орлого	129,874,600.5	203,764,372.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,563,041,935.3	2,303,708,431.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,678,079,019.3	2,501,431,954.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,678,079,019.3	2,501,431,954.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	120,813,180.4	127,249,094.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	61,132,401.6	73,730,739.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,624,854.1	9,475,725.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,942,212.9	12,398,140.5
2104	Хангамж, бараа материалын зардал	3,055,345.2	3,365,818.6
2105	Нормативт зардал	7,884,390.2	5,710,013.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,203,433.2	921,547.7
2107	Томилолт, зочны зардал	929,954.1	223,615.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,092,244.0	8,833,481.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,948,344.9	12,590,012.0
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	605,492,793.3	399,417,600.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	951,773,045.7	1,974,765,260.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	14,837,516.5	6,040,849.2
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.0	0.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	8,828,548.4	8,343,362.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,828,548.4	8,343,362.2
2200	Дотоод эх үүсвэрээр	8,828,548.4	8,343,362.2
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-8,828,548.4	-8,343,362.2
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-8,005,672.7	-2,227,817.2
14	Бусад эх үүсвэр	789.2	151.5
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	8,000,000.0	2,224,500.0
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	0.0	0.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	6,461.9	3,468.7
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-1,996,704.7	-4,530,330.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,605,928.2	7,609,223.5
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,609,223.5	3,078,893.2

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,379,867,459,600.00	2,229,805,356,310.02	150,062,103,289.98	93.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,367,195,959,600.00	2,220,091,957,392.02	147,104,002,207.98	93.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	131,196,629,300.00	120,246,704,739.74	10,949,924,560.26	91.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	77,480,125,300.00	73,224,155,197.58	4,255,970,102.42	94.5
210101	Үндсэн цалин	50,717,806,300.00	48,906,378,963.67	1,811,427,336.33	96.4
210102	Нэмэгдэл	20,526,181,100.00	18,298,310,027.86	2,227,871,072.14	89.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,736,530,500.00	3,507,474,080.19	229,056,419.81	93.9
210104	Урамшуулал	2,499,607,400.00	2,511,992,125.86	-12,384,725.86	100.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,340,427,200.00	9,429,179,522.75	911,247,677.25	91.2
210201	Тэтгэврийн даатгал	7,288,302,600.00	6,693,180,014.45	595,122,585.55	91.8
210202	Тэтгэмжийн даатгал	762,331,000.00	704,991,172.01	57,339,827.99	92.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	609,864,800.00	528,796,838.58	81,067,961.42	86.7
210204	Ажилгүйдлийн даатгал	155,266,100.00	150,474,881.43	4,791,218.57	96.9
210205	Эрүүл мэндийн даатгал	1,524,662,700.00	1,351,736,616.28	172,926,083.72	88.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,279,504,900.00	12,312,671,666.81	966,833,233.19	92.7
210301	Гэрэл, цахилгаан	2,094,252,000.00	1,796,121,231.93	298,130,768.07	85.8
210302	Түлш, халаалт	9,323,180,600.00	9,018,957,776.98	304,222,823.02	96.7
210303	Цэвэр, бохир ус	1,188,393,900.00	885,907,545.90	302,486,354.10	74.5
210304	Байрны түрээс	673,678,400.00	611,685,112.00	61,993,288.00	90.8
2104	Хангамж, бараа материалын зардал	3,140,667,900.00	2,822,870,833.84	317,797,066.16	89.9
210401	Бичиг хэрэг	372,523,200.00	354,566,597.04	17,956,602.96	95.2
210402	Тээвэр, шатахуун	699,062,500.00	545,613,333.90	153,449,166.10	78.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	437,061,200.00	401,584,521.77	35,476,678.23	91.9
210404	Ном, хэвлэл	6,469,600.00	4,842,994.00	1,626,606.00	74.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	545,828,300.00	516,999,605.00	28,828,695.00	94.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,079,723,100.00	999,263,782.13	80,459,317.87	92.5
2105	Нормативт зардал	7,116,839,000.00	5,563,831,696.17	1,553,007,303.83	78.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,169,827,500.00	1,103,938,194.85	65,889,305.15	94.4
210502	Хоол, хүнс	5,234,587,000.00	3,799,645,569.32	1,434,941,430.68	72.6
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	712,424,500.00	660,247,932.00	52,176,568.00	92.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,208,539,000.00	935,376,429.74	273,162,570.26	77.4
210601	Багаж, техник, хэрэгсэл	417,780,000.00	344,335,965.70	73,444,034.30	82.4
210602	Тавилга	60,000,000.00	2,714,800.00	57,285,200.00	4.5
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	54,448,000.00	50,227,429.50	4,220,570.50	92.2
210604	Урсгал засвар	676,311,000.00	538,098,234.54	138,212,765.46	79.6
2107	Томилолт, зочны зардал	146,016,300.00	96,114,040.00	49,902,260.00	65.8
210702	Дотоод албан томилолт	140,538,700.00	96,114,040.00	44,424,660.00	68.4
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	5,477,600.00	0	5,477,600.00	0.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,125,686,700.00	7,482,621,384.66	1,643,065,315.34	82.0

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,797,589,800.00	6,496,740,756.52	1,300,849,043.48	83.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	317,828,300.00	303,881,467.00	13,946,833.00	95.6
210803	Даатгалын үйлчилгээ	134,917,300.00	120,124,904.00	14,792,396.00	89.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	32,615,400.00	22,779,472.00	9,835,928.00	69.8
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	14,948,000.00	10,025,046.00	4,922,954.00	67.1
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	84,384,600.00	74,553,668.94	9,830,931.06	88.3
210807	Газрын төлбөр	45,592,700.00	34,879,733.00	10,712,967.00	76.5
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	334,103,700.00	176,174,196.80	157,929,503.20	52.7
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	363,706,900.00	243,462,140.40	120,244,759.60	66.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,358,823,000.00	8,379,883,968.19	978,939,031.81	89.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,563,500.00	24,397,342.10	12,166,157.90	66.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,322,259,500.00	8,355,486,626.09	966,772,873.91	89.6
211	ХҮҮ	0	0	0.00	0.0
2111	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	0	0	0.00	0.0
211101	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	0	0	0.00	0.0
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	0	0	0.00	0.0
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	0	0	0.00	0.0
212	ТАТААС	399,417,600,000.00	399,417,600,000.00	0.00	100.0
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	399,417,600,000.00	399,417,600,000.00	0.00	100.0
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	399,417,600,000.00	399,417,600,000.00	0.00	100.0
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	0	0	0.00	0.0
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	0	0	0.00	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,836,581,730,300.00	1,700,427,652,652.28	136,154,077,647.72	92.6
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	108,330,807,300.00	96,302,101,759.60	12,028,705,540.40	88.9
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	108,140,356,700.00	96,111,651,363.60	12,028,705,336.40	88.9
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	190,450,600.00	190,450,396.00	204.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,728,250,923,000.00	1,604,125,550,892.68	124,125,372,107.32	92.8
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1,641,936,504,500.00	1,532,864,127,210.58	109,072,377,289.42	93.4
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	325,920,100.00	325,861,880.00	58,220.00	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	81,401,209,000.00	66,566,256,116.91	14,834,952,883.09	81.8
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,057,731,500.00	1,873,224,832.19	184,506,667.81	91.0

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	2,277,384,000.00	2,264,027,050.00	13,356,950.00	99.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	252,173,900.00	232,053,803.00	20,120,097.00	92.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,671,500,000.00	9,713,398,918.00	2,958,101,082.00	76.7
220001	Барилга байгууламж	11,450,500,000.00	8,648,602,211.00	2,801,897,789.00	75.5
221001	Их засвар	883,000,000.00	788,775,007.00	94,224,993.00	89.3
222001	Тоног төхөөрөмж	338,000,000.00	276,021,700.00	61,978,300.00	81.7
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,379,867,459,600.00	2,311,646,520,122.37	68,220,939,477.63	97.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,317,481,089,600.00	2,177,186,228,970.92	140,294,860,629.08	93.9
310001	Улсын төсвөөс санхүүжих	2,317,481,089,600.00	2,177,186,228,970.92	140,294,860,629.08	93.9
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	798,372,400.00	670,272,876.00	128,099,524.00	84.0
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	798,372,400.00	670,272,876.00	128,099,524.00	84.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	61,587,997,600.00	133,790,018,275.45	-72,202,020,675.45	217.2
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	27,357,562,300.00	29,835,043,094.20	-2,477,480,794.20	109.1
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,034,032,300.00	10,404,200,317.96	-6,370,168,017.96	257.9
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	30,196,403,000.00	93,550,774,863.29	-63,354,371,863.29	309.8
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	3,302,013,491.86	-3,302,013,491.86	0.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	1,717,160,161.56	-1,717,160,161.56	0.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	51,373.00	47,625.00		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	126	116		
610001	Төсвийн байгууллага	85	85		
610002	Төсвөөс гадуур байгууллага	41	31		
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	5,637	5,549		
620001	Удирдах ажилтан	205	204		
620002	Гүйцэтгэх ажилтан	4,069	3,993		
620003	Үйлчлэх ажилтан	1,359	1,348		
620004	Гэрээт ажилтан	4	4		
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	39,973	36,411		
632	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	39,973	36,411		
632001	Төрийн өмчит МСҮТ	23,100	23,306		
632002	Хувийн МСҮТ	16,873	13,105		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөг)

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	88,525,831,582.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	88,521,699,582.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,651,089,663.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	468,658,437.68
210101	Үндсэн цалин	332,352,209.52
210102	Нэмэгдэл	94,503,114.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,340,034.00
210104	Урамшуулал	19,048,391.00
210105	Гэрээт ажлын хөлс	16,414,689.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,976,376.68
210201	Тэтгэврийн даатгал	40,908,018.40
210202	Тэтгэмжийн даатгал	525,008.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	420,007.52
210204	Ажилгүйдлийн даатгал	102,121.55
210205	Эрүүл мэндийн даатгал	1,021,220.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,679,190.00
210301	Гэрэл, цахилгаан	4,051,670.00
210302	Түлш, халаалт	9,347,520.00
210304	Байрны түрээс	4,280,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	580,264,794.99
210401	Бичиг хэрэг	255,936,758.46
210402	Тээвэр, шатахуун	91,837,541.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	54,432,008.03
210404	Ном, хэвлэл	30,705,020.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	38,490,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	108,862,967.50
2105	Нормативт зардал	292,882,519.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	41,681,900.00
210502	Хоол, хүнс	210,318,217.30
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	40,882,402.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	319,859,530.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	152,870,400.00
210602	Тавилга	57,434,400.00
210604	Урсгал засвар	109,554,730.00
2107	Томилолт, зочны зардал	136,340,513.00
210701	Гадаад албан томиллолт	3,517,943.00
210702	Дотоод албан томиллолт	132,822,570.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,887,329,021.15
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,803,150,764.15
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,729,937.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	76,448,320.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,905,099,280.46
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,070,190,910.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	834,908,370.46
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	81,870,609,919.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	78,055,274,753.60
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	77,856,735,779.60
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	250,000.00

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	106,950,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	91,338,974.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,815,335,165.92
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	26,382,500.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	12,619,000.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,776,333,665.92
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,132,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,132,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,132,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	88,525,831,582.78
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	88,525,831,582.78
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	49,135,477,282.88
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,039,607,272.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,849,836,713.86
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,500,910,314.04

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд олон жилийн насжилттай авлагыг барагдуулах, салбарын хэмжээнд дотоод хяналтыг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Аудитын хоёрдугаар газрын аудитор С.Бат-Эрдэнэ гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Ц.Хосжаргал, аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 1/929 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны эрхэм зорилго нь “Хөдөлмөр, хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын харилцан хамаарал бүхий цогц бодлогыг хэрэгжүүлж, иргэдийн хөдөлмөрлөх, хөгжих таатай орчин бий болгох, нийгмийн баталгааг дээшлүүлэх замаар хүний хөгжлийг хангахад оршино” гэж тодорхойлсон байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын хууль тогтоомжийн төсөл, бодлого, стратеги, хөтөлбөрийн хувилбар, төслийг боловсруулах, салбарын санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн бодлогыг төлөвлөх;
- Хүн ам, түүний бүлгүүдийн хөгжлийг хангахад чиглэсэн хууль тогтоомжийн төсөл, бодлого, стратеги, хөтөлбөрийн хувилбар, төсөл боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;
- Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, хууль эрх зүйн болон дотоод үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө, дэмжлэгээр хангах, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, сургалтын талаарх хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хөтөлбөр, төсөл боловсруулж хэрэгжүүлэх;
- Хөдөлмөрийн харилцааны талаарх хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;

- Хүн амын нийгмийн баталгааг хангахад чиглэсэн нийгмийн хамгааллын хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;
- Салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, дотоодын хяналт шалгалт, аудит хийх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль
- ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- ЗГ-ын 2020 оны 25 дугаар тогтоол “Нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- ЗГ-ын 2020 оны 44 дүгээр тогтоол “Мэргэжлийн боловсрол, сургалтын талаар авах зарим арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2020 оны 10 дугаар тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2020 оны 78 дугаар тогтоол “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2020 оны 83 дугаар тогтоол “Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын дотуур байранд амьдрах нэг суралцагчийн хоногийн хоолны нормативт зардлыг батлах тухай”
- ЗГ-ын 2020 оны 147 дугаар тогтоол “Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн дүрэм”
- ЗГ-ын 2020 оны 168 дугаар тогтоол “Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2020 оны 183 дугаар тогтоол “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2020 оны 193 дугаар тогтоол “Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнэ”-ийг шинэчлэн батлах
- ЗГ-ын 2020 оны 194 дүгээр тогтоол “Нийгмийн халамжид хамрагдах иргэний хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авах, шийдвэрлэх журам”
- ЗГ-ын 2020 оны 195 дүгээр тогтоол “Төрийн бус өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын зарим байгууллагын талаар авах арга хэмжээний тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт, шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газар нь төлөвлөгөөний дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв, Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор зэрэг 5 байгууллагын 2019, 2020 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, 1,125.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 390.2

сая төгрөгийг зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлж, биелэлтэд хяналт тавьж ажилласан байна.

Ковид-19 цар тахлын хөл хорионы улмаас төлөвлөгөөнд тусгагдсан ГБХЗХГ, ХХҮЕГ-ын үйл ажиллагаанд хийх хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 2,475,114.8 сая төгрөгийн 1.0 хувь буюу 24,751.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 24,147.2 сая төгрөгөөр тогтоосон нь санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайланд залруулга хийгдэж, нийт зардлын дүнд өөрчлөлт орсонтой холбоотой болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 7,609.2 сая, эцсийн үлдэгдэл 3,078.9 сая төгрөг болж, 4,530.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	0.9	1.1	0.2	-
Банканд байгаа бэлэн мөнгө	7,332.00	3,077.8	-4,254.2	100.0
Замд яваа мөнгөн хөрөнгө	276.3		-276.3	-
Хадгаламж			0.0	-
Дүн	7,609.2	3,078.9	-4,530.3	100.00

Эх сурвалж: ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд 1,346.6 сая, арилжааны банкны төгрөгийн харилцах дансанд 1,730.7 сая, гадаад валютын харилцах дансанд 0.5 сая төгрөг тус тус байршиж байна.

Арилжааны банкны үлдэгдэлд Нийгмийн халамжийн сангийн ХААН банканд байршиж байгаа 188 дансны 212.7 сая, Төрийн банканд байршиж байгаа 81 харилцах дансны 1,503.8 сая төгрөгийн үлдэгдэл байна. Үүнээс 1,428.9 сая төгрөг нь олгогдоогүй тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийн үлдэгдэл, 287.7 сая төгрөг нь оны эцэст арилжааны банк дахь харилцах дансанд тооцсон хүүгийн орлого болон буцаасан орлогын үлдэгдэл бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- ХХҮЕГ 2018 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын техник хяналтын зардлын 3.9 сая төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй;
- Монгол Солонгосын Политехник коллеж кассаар төвлөрүүлсэн 20.5 сая төгрөгийн өөрийн орлогыг төрийн сангийн бүртгэлийн дансанд төвлөрүүлэлгүйгээр зарцуулсан.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 190,328.1 сая, эцсийн үлдэгдэл 195,421.2 сая төгрөг болж, 5,093.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажиллагчидтай холбогдсон авлага	120.3	78.7	-41.6	0.0
Төлбөртэй үйлчилгээний авлага	233.4	223.8	-9.6	0.1
Татаас, санхүүжилтийн авлага	98,681.3	101,936.9	3,255.6	52.2
Зээлийн хүүгийн авлага	56.9	79.3	22.4	0.0
Бусад авлага	5,231.3	5,496.0	264.7	2.8
Байгууллагаас авах авлага	3,669.2	3,559.3	-109.9	1.8
Хувь хүмүүсээс авах авлага	1,562.2	1,936.7	374.5	1.0
Зээлийн авлага	86,004.9	87,606.5	1,601.6	44.8
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	78,004.9	77,382.0	-622.9	39.6
Хувь хүмүүст олгосон зээл	44,185.0	44,152.0	-33	22.6
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	33,819.9	33,230.0	-589.9	17.0
Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	8,000.0	10,224.5	2,224.5	5.2
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	8,000.0	10,224.5	2,224.5	5.2
Нийт дүн	190,328.1	195,421.2	5,093.1	100.0

Эх сурвалж: ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Нийт авлагын 52.2 хувийг татаас санхүүжилтийн, 44.8 хувийг Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сангаас олгосон зээлийн авлага эзэлж байна.

Татаас санхүүжилтийн авлагын үлдэгдэлд ХЭДС-ийн харилцах дансны үлдэгдэл 100,924.4 сая төгрөг болон харьяа газруудын нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулагдаагүй 1,012.5 сая төгрөгийн үлдэгдэл бүртгэгдсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас олгосон зээлийн авлага 87,606.5 сая төгрөг болж өмнөх оноос 1,601.6 сая төгрөгөөр өссөн ба үүний 18,805.9 сая төгрөгийн авлага нь гэрээний хугацаа хэтэрсэн 5 жилээс дээш жилийн насжилттай авлага байгаа нь сангийн хөрөнгийн эргэлтийг удаашруулж, улмаар их хэмжээний найдваргүй авлага бий болох эрсдэлтэй байна.

Ажиллагчидтай холбогдсон авлагын 49.6 сая, байгууллагаас авах авлагын 285.7 сая, төлбөртэй үйлчилгээний 191.2 сая, хувь хүмүүсээс авах 368.0 сая төгрөгийн нийт 894.5 сая төгрөгийн 1 жилээс дээш насжилттай авлагын үлдэгдэлтэй байна.

ХЭДС-ийн зээлийн эргэн төлөлт хийгдэхгүйгээс сангийн эх үүсвэр дутагдах, эргэлтэд орохгүй байх, насжилт ихтэй авлага нь найдваргүй авлага болох, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэл бий болсон байна.

Аудитын илрүүлэлт:

- ХЭДС-ийн тайланд ХХААЯ-аас авах авлагын дансны үлдэгдэл, бодит үлдэгдлээс 1,403.6 сая төгрөгөөр илүү бүртгэгдсэн;
- Төсвийг зохистой удирдаагүйгээс ХБХСЗХТ 71.7 сая, ХНХЯ 6.5 сая төгрөгийн авлага үүсгэсэн;
- Авлагын дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй /ХЭДС 987.5 сая, Архангай аймгийн ХЭДС 635.5 сая, Нийслэлийн ХЭГ 19.3 сая, Сүхбаатар дүүргийн ХЭДС 49.6 сая, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төв 8.0 сая /.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 522.6 сая, эцсийн үлдэгдэл 742.0 сая төгрөг болж, 219.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Урьдчилж гарсан зардал	493.9	629.1	135.2	84.8
Бараа материал бэлтгэх урьдчилгаа		62.7	62.7	8.5
Цалингийн урьдчилгаа	28.7	50.2	21.5	6.8
Томилолтын урьдчилгаа			0	-
Дүн	522.6	742.0	219.4	100.0

Эх сурвалж: ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд 16 байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй 50.2 сая төгрөгийн цалингийн урьдчилгаа, 691.8 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээний урьдчилгаа төлбөрүүд бүртгэгдсэн байна. Тухайлбал:

- ГБХЗХГ-ын хүүхдийн 108 утасны 3 дугаар шатны программын хөгжүүлэлтэд төлсөн 72.5 сая;
- Мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээ мэдээллийн төвийн мэргэжил, боловсрол, сургалтын системийн хөгжүүлэлтийн урьдчилгаа төлбөр 328.3 сая;
- ХБХСЗХТ-ийн хүнсний материалын төлбөрийг урьдчилж шилжүүлсэн 72.7 сая;
- Говьсүмбэр аймаг дахь ПТК 20.1 сая, Ховд аймаг дахь Хөгжил ПТК 25.2 сая, Булган аймаг дахь МСҮТ 4.8 сая, Хэнтий аймгийн Бор-Өндөр суман дахь МСҮТ 0.1 сая төгрөгийн зэрэг 50.2 сая төгрөгийн суутгаагүй цалингийн урьдчилгаа;
- Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2015 онд шилжүүлсэн барилгын засварын ажилд урьдчилж төлсөн 27.0 сая төгрөг тус тус бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Говьсүмбэр аймаг дахь ПТК 20.1 сая, Булган аймаг дахь МСҮТ 25.2 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг суутгаагүй;
- Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор нь өмнөх оноос шилжин ирсэн урьдчилгаа 27.0 сая төгрөгийн төлбөрийг барагдуулаагүй;

3.5.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 14,946.2 сая, эцсийн үлдэгдэл 17,024.1 сая төгрөг болж, 2,077.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Тусгай зориулалттай материал	3,352.3	3,414.4	62.1	20.1
Эм боох материал	531.7	587.2	55.5	3.4
Дуусаагүй үйлдвэрлэл	-	18.2	18.2	0.1
Бэлэн бүтээгдэхүүн	113.7	166.9	53.2	1.0

Бичиг хэргийн материал	420.0	348.4	-71.6	2.0
Аж ахуйн материал	5,163.6	5,290.0	126.4	31.1
Сэлбэг хэрэгсэл	516.5	320.6	-195.9	1.9
Түлш, шатах тослох материал	94.7	145.1	50.4	0.9
Барилгын засварын материал	651.3	644.1	-7.2	3.8
Хүнсний материал	575.2	554.9	-20.3	3.3
Бусад хангамжийн материал	3,053.2	5,037.4	1,984.2	29.6
Мал амьтад	474.0	496.9	22.9	2.9
ДҮН	14,946.2	17,024.1	2,077.9	100.0

Эх сурвалж: ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 2,077.9 сая төгрөгөөр өссөн дүнгийн 1,984.2 сая төгрөг нь бусад хангамжийн материал дансны үлдэгдлийн нэмэгдэл байна. Энэ нь Азийн хөгжлийн банкны Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилтийн төсөл, Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл, Германы хамтын ажиллагааны нийгэмлэгээс ХНХЯ-ны харьяа байгууллагуудад үнэ төлбөргүй шилжүүлсэн бараа материалаас голлон нөлөөлсөн байна.

Бусад хангамжийн материалын үлдэгдэл өссөн нь ХБХСЗХТ 631.8 сая, ХНХЯ 102.0 сая, Дархан-Уул аймаг дахь Дархан-Өргөө ПТК 430.0 сая, УУЭХ-ний ПТК 137.0 сая, Барилгын ПТК-ийн 107.0 сая төгрөгийн бараа материалын нэмэгдэлтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Бараа материалын худалдан авалтыг и-баримтаар баталгаажуулаагүй;
- Өнөр бүл хүүхдийн төв 16.2 сая төгрөгийн төсвийн хэмнэлтийг буцаан төвлөрүүлэхгүйгээр бараа материал худалдан авч нөөц үүсгэсэн.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгийн эхний үлдэгдэл 35,741.9 сая, эцсийн үлдэгдэл 31,884.7 сая төгрөг болж, 3,857.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	35,741.9	31,884.7	-3,857.2	100.0
ДҮН	35,741.9	31,884.7	-3,857.2	100.0

Эх сурвалж: ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад эргэлтийн хөрөнгийн дансанд улсын төсвийн хөрөнгө оруулалтын 10 төсөл арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэлээр хуримтлуулан бүртгэсэн 31,884.7 сая төгрөгийн дуусаагүй ажил бүртгэлтэй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 289,191.5 сая, эцсийн үлдэгдэл 300,340.4 сая төгрөг болж, 11,148.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Биет хөрөнгө	253,867.7	261,682.1	7,814.4	87.1
Биет бус хөрөнгө	35,323.7	38,658.2	3,334.5	12.9
Дүн	289,191.5	300,340.4	11,148.9	100.0

Эх сурвалж: ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 889.5 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 11,219.5 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 17,910.0 сая, бусад эх үүсвэрээр 6,716.9 сая, дахин үнэлгээний нэмэгдэл 1,069.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, балансаас балансад шилжүүлсэн 6,975.4 сая, акталсан 3,800.0 сая, дахин үнэлгээний хорогдол 2,199.6 сая, бусад хэлбэрээр 67.3 сая, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 173.6 сая төгрөгөөр тус тус хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд яамны хөрөнгө оруулалт их засварын тайланд бүртгэлтэй Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Хөгжлийн төвийн барилгын гадна шугам сүлжээний ажлын 1,895.5 сая төгрөг, Орхон аймаг дахь ХАА-н МСҮТ-ийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилга байгууламжийн 294.5 сая, Барилгын ПТК-ийн өөрийн хөрөнгөөр барьж буй сургалт, дадлагын барилгын 13.5 сая төгрөг бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- ХХҮЕГ-ын биет бус хөрөнгийн дансанд цаашид ашиглах боломжгүй хэрэгцээ шаардлагагүй болсон 7 төрлийн 792.3 сая программ хангамж бүртгэлтэй;
- Үндсэн хөрөнгийн дансанд биетээр оршин байхгүй хөрөнгө бүртгэлтэй. /Налайх дүүргийн ХХҮХ 19.4 сая, Сонгинохайрхан дүүргийн ХХҮХ 1.1 сая/

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 36,595.1 сая, эцсийн үлдэгдэл 45,609.3 сая төгрөг болж, 9,014.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	28,371.8	29,626.9	1,255.1	65.0
Богино хугацаат зээлийн өглөг	7.7	1,612.1	1,604.4	3.5
Өглөг	5,899.2	9,464.1	3,564.8	20.8
Урьдчилж орсон орлого	22,464.8	18,550.6	-3,914.2	40.7
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,223.3	15,982.4	7,759.1	35.0
Урт хугацаат зээл	8,223.3	15,982.4	7,759.1	35.0
НИЙТ ӨР ТӨЛБӨР	36,595.1	45,609.3	9,014.2	100.0

Эх сурвалж: ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдлийг төрлөөр нь авч үзвэл 5.4 хувийг хувь хүмүүст олгосон зээл, 29.2 хувийг хувь хүмүүст төлөх өглөг, 62.6 хувийг урьдчилж орсон орлого, 2.8 хувийг бусад өр төлбөр эзэлж байна.

- Хувь хүмүүст олгосон зээлийн үлдэгдэлд ХЭДС-аас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт олгох улсын төсвийн санхүүжилт дутуугаас үүссэн 1,612.1 сая төгрөгийн өр;
- Хувь хүмүүст төлөх өглөгийн үлдэгдэлд Нийгмийн халамжийн сангаас иргэдэд олгох тэтгэвэр тэтгэмжийн 1,428.9 сая, Мэргэжлийн боловсролыг дэмжих сангаас суралцагчдын тэтгэмж, хувьсах зардлыг олгоогүйгээс үүссэн 6,801.6 сая, бусад 18 байгууллагад хамаарах 420.0 сая төгрөгийн өр;
- Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэлд ХЭДС-ийн ажлын байрны төлбөрийн 17,913.4 сая төгрөгийн орлого болон ажлын байрны буцаалтад олгохоор тооцсон 331.1 сая төгрөгийн орлого, Сэргээн засалт сургалт үйлдвэрлэлийн төвийн аймаг, дүүргүүдийн Халамж үйлчилгээний хэлтсээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан протезын төлбөрийн урьдчилгаа 60.2 сая, Олон улсын хүүхдийн найрамдал цогцолборын амрагч хүүхдүүдийн урьдчилж төлсөн 111.2 сая төгрөгийн орлого тус тус бүртгэлтэй байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд ХЭДС-гийн санхүүгийн тайланд бүртгэлтэй Дэлхийн банкны санхүүжилтээр арилжааны банкаар дамжуулан олгох жижиг зээлийн төлбөр, валютын ханшны зөрүүгээс үүссэн өр байна.

Аудитын илрүүлэлт:

- Төсвийг зохистой удирдаагүйгээс шинээр өр төлбөр үүсгэсэн /ХХҮЕГ 4.9 сая, Өмнөговь аймгийн ХХҮГ 3.8 сая, Булган аймгийн ХЭДС 79.7 сая, Дорноговь аймгийн ХЭДС 91.1 сая, ХНХЯ 4.0 сая/;
- Нийслэлийн хөдөлмөр, эрхлэлтийн газар нь 13.1 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.

3.5.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 501,744.3 сая, эцсийн үлдэгдэл 502,882.0 сая төгрөг болж, 1,137.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 8. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	117,562.5	124,234.9	6,672.4	24.7
Хуримтлагдсан үр дүн	266,337.3	260,560.2	-5,777.1	51.8
Өмнөх үеийн үр дүн	233,988.0	262,699.6	28,711.6	52.2
Тайлант үеийн үр дүн	32,349.3	(2,139.4)	-34,488.7	-0.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	117,844.6	118,086.9	242.4	23.5
Засгийн газрын хувь оролцооны дүн	501,744.3	502,882.0	1,137.7	100.0

Эх сурвалж: ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал дансны үлдэгдэл 124,234.9 са төгрөг болж 6,672.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Завхан аймгийн Тосонцэнгэл суман дахь МСҮТ улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан барилгыг буруу бүртгэснийг залруулга хийсэн, эзэмших эрхтэй газрын өртгийг 2 байгууллага 16.3 сая төгрөгөөр бууруулж, 5 байгууллага 183.7 сая төгрөгөөр нэмж бүртгэснээс шалтгаалжээ.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 118,086.9 сая төгрөг болж 242.4 сая төгрөгөөр өссөн нь Говьсүмбэр аймгийн ХХҮГ, Төв аймаг дахь МСҮТ, ГБХЗХГ үлдэх өртөггүй хөрөнгийг дахин үнэлж 536.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 11 байгууллага акталсан үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүний буцаалт 294.0 сая төгрөгийг хасч бүртгэснээс шалтгаалжээ.

Хуримтлагдсан үр дүн 260,560.2 сая төгрөг болж 5,777.1 сая төгрөгөөр буурсан нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн залруулга болон тайлант үеийн үр дүн 2,139.4 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Улсын төсвийн орлого бүрдүүлэлт

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд зааснаар ажлын байрны хураамжийн орлогоос 800.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 323.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 476.5 сая төгрөгөөр тасарсан нь Коронавируст халдвар /ковид-19 /-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд хилээр орох, гарах

хөдөлгөөнийг хаасантай холбоотойгоор хөдөлмөр эрхлэх визээр орж ирэх гадаад иргэдийн тоо буурснаас шалтгаалсан байна.

Төсвийн төлөвлөлт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг болон нийт зарлагыг 2,905,003.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 254 дүгээр тогтоолоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны төсвийн хязгаарыг 2,047,429.2 сая төгрөгөөр баталсан ба төсвийн ерөнхийлөн захирагчийн боловсруулж хүргүүлсэн төсвийг 1,307,661.2 сая төгрөгөөр бууруулж 1,597,342.5 сая төгрөгөөр баталсан байна. Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн зарлагыг хэт өндрөөр, бодит бус, үндэслэлгүй боловсруулсан, төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлтэй нийцээгүй тул бууруулсан байна.

2020 оны төсвийн тодотголоор төсвийн нийт зарлагыг нэмэгдүүлж 2,379,867.5 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь УИХ-аас баталсан коронавирусын цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хүрээнд цар тахлын үед хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй, нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор 0-18 насны хүүхдэд сар бүр 100.0 мянган төгрөг олгохоор, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай бага орлоготой өрхийн насанд хүрсэн иргэн бүрт олгодог хүнсний талоныг 32.0 мянган төгрөг, нийгмийн халамжийн сангаас олгодог тэтгэвэр, тэтгэмжийг иргэн бүрт 100.0 мянган төгрөг болгож нэмэгдүүлэх шийдвэр гарсантай холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийн тодотголоор төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 12 хөтөлбөрт зориулан 2,379,867.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,367,196.0 сая төгрөгийг урсгал зардалд, 12,671.5 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын эх үүсвэрийг улсын төсвөөс 2,317,481.1 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас 798.4 сая төгрөгийг санхүүжүүлэхээр, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 61,588.0 сая төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,200,062.1 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас 670.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, улсын төсвөөс 117,419.0 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас 128.1 сая төгрөгийн санхүүжилт тус тус дутуу олгогдсон байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 29,835.0 сая төгрөг бүрдүүлж, 2,477.5 сая төгрөгөөр давсан нь ХЭДС-аас гадаадын иргэнд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох үйлчилгээний төлбөрийн орлого 4,309.7 сая төгрөгөөр илүү төвлөрснөөс шалтгаалжээ.

Туслах үйл ажиллагааны орлого 10,404.0 сая төгрөг бүрдүүлж, 6,370.2 сая төгрөгөөр давсан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж байгууллагуудын судалгааг гаргаж, албан шаардлага өгч ажилласнаар ХЭДС-ийн орлого 7,039.1 сая төгрөг бүрдсэнтэй холбоотой байна.

Төсвийн нийт зардал 2,229,805.4 сая төгрөг буюу 93.7 хувийн гүйцэтгэлтэй гарч, 150,062.1 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь дараах гол шалтгаантай байна. Үүнд:

- Бараа ажил, үйлчилгээний зардал 10,949.9 сая төгрөгөөр дутуу зарцуулагдсан нь Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлын улмаас мэргэжлийн боловсролын байгууллагууд цахимаар хичээллэсэн, Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор амрагч аваагүй, ХБХСЗХ-ийн төв нь орон тоо дутуу ажилласан зэргээс хамаарч салбарын хэмжээнд цалин, НДШ, байр ашиглалттай холбоотой зардал, нормативт зардал, хичээл практикийн зардлууд дутуу зарцуулсан;

- Засгийн газрын урсгал шилжүүлгийн зардал 12,028.7 сая төгрөгөөр дутуу зарцуулагдсан нь нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан, тэтгэмж авах эрх үүссэн эхийн төлбөл зохих шимтгэлийн 50 хувийг тэтгэмжийн даатгалын сангаас, 50 хувийг эх өөрөө төлнө гэж заасны дагуу олгож байгаа тэтгэмжийг сүүлийн 2 жилийн төрөлтийн судалгаан дээр үндэслэн 2020 онд 13,639.2 сая төгрөгийн төсөв батлагдсан боловч 1,993.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан;
- Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардал 109,072.4 сая төгрөгөөр дутуу зарцуулагдсан нь улсын төсвөөс санхүүжилтийг дутуу олгож, тухайн зардлыг нэмэлт санхүүжилт буюу Азийн хөгжлийн банкны Хүнс тэжээл, нэмэлт санхүүжилтийн төсөл, гадаад эх үүсвэрээс олгосон тусламжийн орлогоос зарцуулсан;
- Мэргэжлийн боловсролын байгууллагад элсэгчдийн тоо төлөвлөснөөс 16.7 хувиар бага, мэргэжлийн түр сургалт, МСҮТ-ийн хэв шинжийг агуулаагүй сургалтын төвийн ирц 75 хувиас доош суралцагч нарт тэтгэлэг олгоогүй зэргээс хамаарч төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардал хэмнэгдсэн;
- Хөрөнгийн зардал 2,958.1 сая төгрөгөөр дутуу зарцуулагдсан нь худалдан авах ажиллагаа болон хөл хорио тогтоосонтой холбоотойгоор төсөл, арга хэмжээний гүйцэтгэл удааширсан зэргээс голлон нөлөөлсөн байна.

Урсгал санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдэл 130,987.0 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 46 төсөл, арга хэмжээнд 12,671.5 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 9,713.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Аймаг, нийслэлд эрх шилжсэн 23 ажлын санхүүжилтэд 4,877.6 сая, эрх шилжээгүй 23 ажлын 3,730.3 сая төгрөгийг олгож, 1,105.0 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцааны дансанд төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын илрүүлэлт:

- Төсөвт зохицуулалт хийх зөвшөөрөлгүйгээр зардлын эдийн засгийн ангиллын арга хэмжээ, бүлэг хооронд 68.6 сая төгрөгийг гүйлгэн зарцуулсан / ХХҮЕГ 34.6 сая, БГД ХХҮХ 2.9 сая, БЗД ХХҮХ 1.0 сая, НД ХХҮХ 3.8 сая, Төв аймгийн ХХҮГ 6.0 сая, Сэлэнгэ аймгийн ХХҮГ 1.1 сая, Увс Улаангом Политехник коллеж 6.9 сая, Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехник коллеж 12.2 сая/;
- Шүүхийн шийдвэрээр олгосон 150.9 сая төгрөгийн нөхөн төлбөрийг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй /ХНХЯ 20.7 сая, Говь-Алтай аймгийн ХХҮГ 7.4 сая, ГБХЗХГ 17.6 сая, Монгол-Солонгосын Политехник коллеж 24.1 сая, Ховд аймаг дахь Хөгжил Политехник коллеж 81.1 сая/;
- ХНХЯ 73.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахим системээр зохион байгуулаагүй, босго үнийн дүнгээс давсан бараа, ажил үйлчилгээний 19.7 сая төгрөгийн худалдан авалтыг шууд гэрээ байгуулж гүйцэтгэсэн.

Нэмэлт төсөв:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 49,135.5 сая, Засгийн газрын нөөц сан болон түүнтэй адилтгах бусад шатны төсвийн захирагчаас нөөц хөрөнгөөс 1,039.6 сая, дээд шатны төсвийн төсөв захирагчаас хуваарилсан хөрөнгө 2,849.8 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 35,500.9 сая, нийт 88,525.8 сая төгрөгийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлжээ.

Үүнээс бараа үйлчилгээний зардалд 6,651.1 сая, хөрөнгийн зардалд 4.1 сая, нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж болон төрөөс иргэдэд олгох тэтгэвэр, тэтгэмжийн зардалд 78,055.3 сая төгрөгийг зарцуулж, 3,815.3 сая төгрөгийг улс болон орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитын гол онцлох зүйлс гэдэг нь бидний мэргэжлийн үнэлэмжээр тайлант жилийн тусдаа санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал ач холбогдол бүхий зүйлс юм. Эдгээр онцлох зүйлс нь бидний тусдаа санхүүгийн тайланд аудит хийх болон дүгнэлт өгөх явцад шийдвэрлэгдсэн бөгөөд бид эдгээр асуудлуудад тусдаа дүгнэлт өгөхгүй юм.

Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн хүрээнд Засгийн Газрын 2020 оны 140 дүгээр тогтоолоор “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ыг баталсан байна. Энэхүү журмын 6.4-т “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь чөлөөлөгдөх нийгмийн даатгалын шимтгэл, дэмжлэгт шаардагдах хөрөнгийн тухайн сарын хэмжээг Сангийн яамтай дараа сарын 25-ны өдрийн дотор тооцоо нийлж, баталгаажуулна” гэж заасан байна. Дээрх хууль, журмын дагуу 2020 оны 4-р сарын 01-ний өдрөөс 2020 оны 12-р сарын 31-ний өдрийн хооронд 38399 ажил олгогчийн 410678 албан журмын даатгуулагчийн 619,055.9 сая, 169174 сайн дурын даатгуулагчийн 23,533.4 сая төгрөгийн чөлөөлөгдсөн нийгмийн даатгалын шимтгэлийн, 199404 даатгуулагчийн 39,880.5 сая төгрөгийн ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон дэмжлэгийн нийт 682,469.9 сая төгрөгийн авлага хуримтлагдсан байна.

Цар тахлын хөл хорионы улмаас аудитын ажлын хамрах хүрээний хувьд хязгаарлагдмал байсан тул аудитын хангалтай зохистой нотолгоог олж авахад хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн.

3.8 Аудитын гол асуудал

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт нийт 8 чиглэлийн 25 үзүүлэлт тусгасан байна. Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн байна. Үнэлгээгээр 100.0 хувийн биелэлттэй 17, 90.0 хувийн биелэлттэй 3, 70.0 хувийн биелэлттэй 4, 30.0 хувийн биелэлттэй 1 арга хэмжээ байна. Нийт үнэлгээгээр 2020 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон үзүүлэлтийн биелэлтийг 91.2 хувьтай байна гэж дүгнэсэн байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зээл авсан иргэний тоо 1000 байх гэсэн зорилтот түвшинд хүрээгүй 30.0 хувийн биелэлттэй гарсан байна.

3.9 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд төсвийн ерөнхийлөн захирагч 151 мэдээлэл байршуулахаас 114 мэдээллийг хугацаанд нь, 17 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 төрлийн 693.4 сая төгрөгийн 18 мэдээллийг байршуулаагүй байна. Үүнд: Төсөл арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, худалдан авах ажиллагааны тайлан, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн зэргийг мэдээлээгүй байна.

Шилэн дансны цахим хуудсанд төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагууд тайлант хугацаанд 24231 мэдээлэл байршуулахаас 18286 мэдээллийг хугацаанд нь, 2945 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 3000 мэдээллийг байршуулаагүй байна. Аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж, нийт 7,055.6 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс, 6,229.5 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 36 албан шаардлага хүргүүлж, 826.2 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 49 зөвлөмжийг өгсөн.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид алдаа, зөрчлийг арилгах, сахилгын шийтгэл ноогдуулах 2 албан шаардлага, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх 8 зөвлөмж хүргүүлсэн нь дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	2	63.1	1		50.0
Зөвлөмж	8	6,976.4	7	6,851.0	87.5
ДҮН	10	7,039.5	8	6,851.0	80.0

Ажлаас үндэслэлгүй чөлөөлөгдсөн нь Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон төрийн албан хаагчийн ажилгүй байсан хугацааны нөхөн төлбөрт төсвөөс олгосон хөрөнгийг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлэх албан шаардлага, ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөлтөд дүн шинжилгээ хийж, үндэслэлтэй төлөвлөх, гүйцэтгэлийг хангуулж ажиллах талаар хүргүүлсэн зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна.

3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын явцад анхаарал татахуйц, дараагийн аудитаар дахин авч үзэх дараах асуудал байна. Үүнд:

- ХНХС-ын хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагаа, гэрээний хэрэгжилтийг “Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” гүйцэтгэлийн аудитаар хамруулах;
- БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар баригдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Хөгжлийн төвийн барилга болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн гадна шугам сүлжээний ажлыг ашиглагч байгууллагад шилжүүлсэн эсэхийг дараагийн аудитад хамруулна.

4. Аудитын илрүүлэлт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 164 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс, 155 байгууллага аудит хамрагдсан, 7 байгууллагад итгэл үзүүлсэн, 2 байгууллага аудитад хамрагдаагүй байна. Үүнд: Сонгинохайрхан дүүргийн ЖДҮДТ Төсвийн хуульд заасан хугацаанд санхүүгийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүйгээс, Баянзүрх дүүргийн ЖДҮДТ тайлант онд үйл ажиллагаа явуулаагүйгээс аудитад хамрагдаагүй байна.

Аудитад хамрагдсан 17 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 138 байгууллагад дүгнэлт хүргүүллээ. Үүнд: “Зөрчилгүй” 122, “Хязгаарлалттай” 15, “Сөрөг” 1 дүгнэлт өгөв.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 161,649.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 130,348.0 сая төгрөгийн 137 алдааг аудитын явцад залруулж, 425.8 сая төгрөгийн зөрчилд 68 төлбөрийн акт тогтоож, 22,591.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 81, хариуцлага тооцуулах 3 албан шаардлага хүргүүлж, 8,284.3 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 234 зөвлөмж өгөв.

4.1 Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Харьяа байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 114,918.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 84,511.6 сая төгрөгийн 134 алдааг аудитын явцад залруулж, 425.8 сая төгрөгийн зөрчилд 68 төлбөрийн акт тогтоож, 22,591.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 81 хариуцлага тооцуулах 2 албан шаардлага хүргүүлж, 7,389.6 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 231 зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт № Хязгаарлалттай болон сөрөг санал дүгнэлт өгсөн байгууллагууд.

№	Байгууллагын нэр	№	Байгууллагын нэр
Хязгаарлалттай			
1	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	9	Нийслэлийн хөдөлмөрийн газар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
2	Мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээ мэдээллийн төв	10	Баянгол дүүргийн ХЭДС
3	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв	11	Сүхбаатар дүүргийн ХЭДС
4	Баян-Өлгий аймгийн ХХҮГ	12	Сонгинохайрхан дүүргийн ХЭДС
5	Налайх дүүрэг ХХҮХ	13	Хан Уул дүүргийн ХЭДС
6	Сүхбаатар дүүргийн ХХҮХ	14	Багануур дүүргийн ХЭДС
7	Говьсүмбэр аймаг дахь ПТК	15	Налайх дүүргийн ХЭДС
8	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв сан		
Сөрөг			
1	Монгол -Солонгосын Политехник коллеж		

4.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Аудитаар нийт 46,730.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 45,836.4 сая төгрөгийн алдааг залруулж, 1 зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж, 894.5 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгөв.

Залруулсан алдаа

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 45,836.4 сая төгрөгийн залруулга хийгдлээ. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллага хооронд үүссэн 7.6 сая төгрөгийн орлого болон зардлын давхардсан ажил гүйлгээг дутуу устгасан;
- Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд хөрөнгө оруулалтын орлого, зардлыг 124.8 сая төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Мөнгөн гүйлгээний тайлангаас давхардсан орлого, зарлагын тохируулгыг бүрэн хийгээгүйгээс төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлын төлөвлөгөө 51,212.0 сая, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 45,700.9 сая төгрөгөөр тус тус илүү тайлагнагдсан байна.

Албан шаардлага

Шилэн дансны цахим хуудсанд төсвийн ерөнхийлөн захирагч 151 мэдээлэл байршуулахаас 17 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан 16 төрлийн 693.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, худалдан авах ажиллагааны тайлан, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн зэргийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор", 6.1.2-т "хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор", 6.1.5-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" 6.4.3-т "тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан" 6.4.6-д "худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

2.Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага Монгол-Солонгосын Политехник коллежийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар тус байгууллага нь кассаар хүлээн авсан өөрийн орлогыг төрийн сангийн бүртгэлийн дансанд төвлөрүүлээгүй, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, Засгийн газраас тогтоосон цалингийн сүлжээ, шатлалыг баримтлаагүйгээс цалин илүү олгосон, ажиллагсдын цалингаас суутгавал зохих НДШ, ХХОАТ-ыг дутуу суутгасныг байгууллагын төсвөөс төлсөн, урьдчилж орсон орлогыг данс буруу бүртгэснээс санхүүгийн тайланд орлого дутуу илэрхийлэгдсэн зэрэг зөрчил гаргасны улмаас "Сөрөг" санал дүгнэлт авсан байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, ..., санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг санал дүгнэлт авсан, ... бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага өгөв.

5. Менежментийн захидал

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн оруулав. Үүнд:

5.1 Балансын данстай холбоотой асуудал.

5.1.1 Илрүүлэлт:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний 26 байгууллагын санхүүгийн тайланд 5 хүртэлх жилийн насжилттай ..сая, 5-аас жилийн насжилттай ...сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна.

Мөн Хөдөлмөр эрхлэх дэмжих сангийн 5 -аас жилийн насжилттай 18,805.9 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна.

нэг жилээс дээш насжилттай (хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас бусад) ажиллагчидтай холбогдсон 49.6 сая, байгууллагаас авах 285.7 сая, төлбөртэй үйлчилгээний 191.2 сая, хувь хүмүүсээс авах 368.0 сая төгрөгийн, нийт **894.5** сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Үүний 73.8 хувийг 5-аас дээш жилийн, 26.2 хувийг 1-5 хүртэлх жилийн насжилттай авлага байна.

Мөн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт авлагын 45 хувь буюу 87,606.5 сая төгрөг нь Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас олгосон зээлийн авлага эзэлж байгаа бөгөөд үүний 18,805.9 сая төгрөгийн авлага нь зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн 5 жилээс дээш жилийн насжилттай авлага байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10-т "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээр уг хөрөнгийг нөхөн төлүүлэх, санхүүжилтийг зогсоох, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх", 30.1.16-д "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогыг бүрдүүлэх, хөрөнгийн хуваарилалтын төслийг боловсруулах, батлуулах, хөрөнгийг баталсан хуваарийн дагуу зарцуулах, хяналт тавих, тайлагнах" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "Эрх ба үүрэг", "Үнэн зөв байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

5.1.2 Өгсөн зөвлөмж:

- Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд бүртгэлтэй өмнөх оноос шилжин ирсэн болон насжилт ихтэй ажиллагчидтай холбогдсон, байгууллага, хувь хүнээс авах авлагын үлдэгдлийг бууруулах ажлыг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллах.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулах ажилд төсвийн ерөнхийлөн захирагчийн зүгээс үр дүнтэй хяналт тавьж, сангийн хөрөнгийн эргэлт, үр өгөөжийг дээшлүүлэх.

5.2 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа

5.2.1 Илрүүлэлт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэгддэг боловч үйл ажиллагаа нь бүрэн зогссон Баянзүрх дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн өр төлбөрийн үлдэгдлийг барагдуулж, татан буулгах саналыг холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэр гаргуулах, хөрөнгийн үлдэгдлийг шилжүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Эрхэлсэн салбар, хүрээний төрийн өмчит хуулийн этгээдийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, захиалга, төлөвлөлт, хөрөнгө оруулалт, шаардлагатай бусад асуудлаар санал боловсруулж холбогдох газарт оруулна", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг,

төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 14.2.11-д "төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад 3-5 жил тутамд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.2.2 Өгсөн зөвлөмж:

Үйл ажиллагаа нь бүрэн зогссон дээрх байгууллагын өр төлбөрийг барагдуулах ажлыг зохион байгуулж, үйл ажиллагааг татан буулгах саналыг холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэх.

5.3 Удирдлагын дээд болон дотоод хяналт

5.3.1 Илрүүлэлт:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 31,301.7 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрсэн, 16 байгууллагын санхүүгийн тайланд Хязгаарлалттай, 1 байгууллагад Сөрөг санал дүгнэлт өгөгдсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасантай нийцээгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.3.2 Өгсөн зөвлөмж:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын тогтолцоо, үйл ажиллагааг сайжруулж, аудитаар илэрсэн алдаа, зөрчилд дүн шинжилгээ хийж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар нэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/Д	№	Аудитын нэр	Аудитад хамрагдсан хэлбэр, дүгнэлтийн төрөл						Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт						
			Түүвэрт	Итгэл үзүүлсэн	Аудит хийгдээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс	Төлбөрийн акт		Албан шаардлага		зөвлөмж	
										Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
I.ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ															
1	1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын санхүүгийн нэгтгэсэн тайлан					1					1		3	894.5
ДҮН							1					1		1	894.5
II.ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ															
2	1	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан.				1			1	3.4					
ДҮН						1			1	3.4					
III.ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН															
Нийгмийн халамжийн сан															
3	1	Нийгмийн халамжийн төв сан				1						1		1	180.0
4	2	Архангай аймгийн нийгмийн халамжийн сан				1									
5	3	Багануур дүүргийн нийгмийн халамжийн сан				1			1	1.2				1	
6	4	Багахангай дүүргийн нийгмийн халамжийн сан				1									
7	5	Баян-өлгий аймгийн нийгмийн халамжийн сан				1									
8	6	Баянхонгор аймгийн нийгмийн халамжийн сан				1									
9	7	Баянгол дүүргийн нийгмийн халамжийн сан				1								2	31.1
10	8	Баянзүрх дүүргийн нийгмийн халамжийн сан				1									
11	9	Булган аймгийн нийгмийн халамжийн сан				1									
12	10	Говь-Алтай аймгийн нийгмийн халамжийн сан				1			1	5.3					

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

13	11	Говьсүмбэр аймгийн нийгмийн халамжийн сан	1										
14	12	Дархан-Уул аймгийн нийгмийн халамжийн сан		1					1		1	2.1	
15	13	Дорноговь аймгийн нийгмийн халамжийн сан		1									
16	14	Дорнод аймгийн нийгмийн халамжийн сан		1					1		1	8.5	
17	15	Дундговь аймгийн нийгмийн халамжийн сан	1										
18	16	Завхан аймгийн нийгмийн халамжийн сан		1									
19	17	Налайх дүүргийн нийгмийн халамжийн сан		1			1	13.0	1	10.2	1	183.9	
20	18	Орхон аймгийн нийгмийн халамжийн сан		1			1	0.4	1	0.4	2	8.8	
21	19	Өвөрхангай аймгийн нийгмийн халамжийн сан		1									
22	20	Өмнөговь аймгийн нийгмийн халамжийн сан		1									
23	21	Сүхбаатар дүүргийн нийгмийн халамжийн сан		1							3	4.2	
24	22	Сүхбаатар аймгийн нийгмийн халамжийн сан	1										
25	23	Сонгино хайрхан дүүргийн нийгмийн халамжийн сан		1							4	37.4	
26	24	Сэлэнгэ аймгийн нийгмийн халамжийн сан		1									
27	25	Төв аймгийн нийгмийн халамжийн сан		1									
28	26	Увс аймгийн нийгмийн халамжийн сан		1									
29	27	Ховд аймгийн нийгмийн халамжийн сан		1			1	0.6			1		
30	28	Хөвсгөл аймгийн нийгмийн халамжийн сан		1							2		
31	29	Хан-Уул дүүргийн нийгмийн халамжийн сан		1			1	4.1			1		
32	30	Хэнтий аймгийн нийгмийн халамжийн сан		1									
33	31	Чингэлтэй дүүргийн нийгмийн халамжийн сан		1									
ДҮН			3	28			6	24.6	5	10.6	20	456.0	
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан													
34	1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв сан				1			4	20,350.3	3	3,378.5	
35	2	Архангай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан		1					1	635.5	2	65.8	
36	3	Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан		1									
37	4	Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан		1			1	0.7			4	318.6	
38	5	Булган аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан		1							1	79.7	
39	6	Говь-Алтай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан		1			1	2.7	1	3.6			
40	7	Говь сүмбэр аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан		1							1	1.6	
41	8	Дархан Уул аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан		1					1	0.7			
42	9	Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан		1					1		1	91.1	
43	10	Дорнод аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан		1									

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

44	11	Дундговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан				1					1			
45	12	Завхан аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан				1								
46	13	Орхон аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан				1					1			
47	14	Өвөрхангай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан				1					1	6.5		
48	15	Өмнөговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан				1								
49	16	Сүхбаатар аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан				1		1	210.0	1	200.0	1		
50	17	Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан				1				1	2.0			
51	18	Төв аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан				1							1	2.2
52	19	Увс аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан				1								
53	20	Ховд аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан				1							5	69.5
54	21	Хөвсгөл аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан				1							1	
55	22	Хэнтий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан				1							1	
56	23	Нийслэлийн хөдөлмөрийн газар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан					1		1	9.4	3	64.1	2	50.3
57	24	Баянгол дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан					1				1	228.8	4	147.6
58	25	Баянзүрх дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан				1								
59	26	Сүхбаатар дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан					1		1	3.3	1	9.6	1	49.6
60	27	Сонгинохайрхан дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан					1		2	13.3	2	181.0	3	144.7
61	28	Хан Уул дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан					1						1	40.7
62	29	Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан				1								
63	30	Багануур дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан					1				1	94.6	1	5.5
64	31	Багахангай дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан					1							
65	32	Налайх дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан					1				1	17.3	1	113.8
66	33	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төв Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1											
67	34	ХНХСНИнститут Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1											
68	35	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1										1	21.0
ДҮН			3			24	8		7	239.4	22	21,794.0	36	4,580.3
69	1	V.Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан				1					2			
Засгийн газрын тусгай сангийн дүн			3	3		53	8		13	264.0	29	21,804.6	56	5,036.2

IV. ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

70	1	Хөдөлмөр, халамийн үйлчилгээний ерөнхий газар	1								1	34.6	5	11.2
71	2	Архангай аймгийн ХХҮГ		1										
72	3	БНСУ дахь хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв	1											
73	4	Баянгол дүүргийн ХХҮХ			1								3	6.5
74	5	Баянзүрх дүүргийн ХХҮХ			1			1	0.2				3	3.4
75	6	Багануур дүүргийн ХХҮХ			1			1	0.2				2	4.3
76	7	Булган аймгийн ХХҮГ			1			1	0.4				4	1.6
77	8	Баянхонгор аймгийн ХХҮГ			1									
78	9	Багахангай дүүргийн ХХҮХ			1								1	0.1
79	10	Баян-Өлгий аймгийн ХХҮГ				1		1	1.6	1	30.0			
80	11	Говь-Алтай аймгийн ХХҮГ			1			2	1.4	2	7.6			
81	12	Говьсүмбэр аймгийн ХХҮГ			1			0					1	
82	13	Дархан -Уул аймгийн ХХҮГ			1			1	0.8				4	22.9
83	14	Дорнод аймгийн ХХҮГ			1			1	1.8	2	4.8			
84	15	Дорноговь аймгийн ХХҮГ			1								1	6.2
85	16	Дундговь аймгийн ХХҮГ			1					2	3.4			
86	17	Завхан аймгийн ХХҮГ			1					0			0	
87	18	Налайх дүүрэг ХХҮХ				1				1	19.4		4	46.0
88	19	Нийслэлийн хөдөлмөр халамж үйлчилгээний газар			1								2	
89	20	Орхон аймгийн ХХҮГ		1										
90	21	Сүхбаатар дүүргийн ХХҮХ				1							6	262.5
91	22	Сонгинохайрхан дүүргийн ХХҮХ			1			1	0.9				5	2.3
92	23	Сэлэнгэ аймгийн ХХҮГ			1			0		2	4.8			
93	24	Сүхбаатар аймгийн ХХҮГ		1										
94	25	Төв аймгийн ХХҮГ			1					1	6.0		1	
95	26	Увс аймгийн ХХҮГ			1									
96	27	Орхон аймгийн ХХҮГ-ын ахмадын сан	1											
97	28	Хан-Уул дүүргийн ХХҮХ-ийн ахмадын сан	1											
98	29	Ховд аймгийн ХХҮГ			1								2	4.1
99	30	Хан-Уул дүүргийн ХХҮХ			1								1	2.4
100	31	Хэнтий аймгийн ХХҮГ			1									
101	32	Хөвсгөл аймгийн ХХҮГ			1								2	172.4
102	33	Чингэлтэй дүүргийн ХХҮХ			1			0		0			0	
103	34	Япон улс дахь ХНХҮТ	1											
104	35	Өвөрхангай аймгийн ХХҮГ			1									
105	36	Өмнөговь аймгийн ХХҮГ			1								1	3.8

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

106	37	Архангай аймаг дахь МСҮТ				1				2	16.4				
107	38	Барилгын ПТК				1						1	2.1	1	8.5
108	39	Баян-Өлгий аймаг дахь МСҮТ				1									
109	40	Баянхонгор дахь МСҮТ				1				1	0.4	1	16.3	2	1.5
110	41	Булган аймаг дахь МСҮТ				1						1	0.6	5	20.7
111	42	Булган аймаг дахь ХАА-н МСҮТ				1								9	4.8
112	43	Говь-Алтай аймаг дахь МСҮТ				1				4	3.8	2	19.5	3	15.7
113	44	Говьсүмбэр аймаг дахь ПТК					1			3	33.9	4	21.0	2	75.3
114	45	Дархан-Уул аймаг дахь Дархан-Өргөө ПТК				1				3	1.0	1	4.5	7	664.4
115	46	Дархан-Уул аймаг дахь МСҮТ				1								2	11.8
116	47	Дархан-Уул аймаг дахь УУЭХ-ний ПТК				1						1	0.1	3	4.2
117	48	Дорноговь аймаг дахь МСҮТ				1								1	
118	49	Дорнод аймаг дахь МСҮТ	1												
119	50	Дорнод аймаг дахь ПТК				1				1	2.3	1	23.2	2	36.3
120	51	Дундговь аймаг дахь МСҮТ				1						2	8.1		
121	52	Завхан аймаг дахь МСҮТ				1				2	5.2			3	8.0
122	53	Завхан аймгийн Тосонцэнгэл суман дахь МСҮТ				1				1	5.9	1	3.6	4	8.0
123	54	Монгол Солонгосын ПТК					1			4	3.2	3	46.8	7	164.5
124	55	Налайх дүүрэг дэхь МСҮТ				1				2	2.3			2	9.7
125	56	Орхон аймаг дахь МСҮТ				1				1	1.1	2	6.2	3	7.6
126	57	Орхон аймаг дахь ХАА-н МСҮТ				1				2	2.6			3	0.2
127	58	Сэлэнгэ аймаг дахь МСҮТ				1				4	7.2				
128	59	Сэлэнгэ аймгийн Мандал суман дахь Зүүнхараа ПТК				1				2	14.7			1	2.3
129	60	Сэлэнгэ аймгийн Шаамар суман дахь МСҮТ				1				2	0.6	2	2.4		
130	61	Сүхбаатар аймаг дахь МСҮТ				1				1	1.0	1	0.4		
131	62	Төв аймаг дахь МСҮТ				1				1	0.3			3	9.6
132	63	Төв аймгийн Баянчандмань суман дахь МСҮТ				1				1	2.4			1	9.8
133	64	Төв аймгийн Заамар суман дахь МСҮТ				1								5	103.0
134	65	Төв аймгийн Эрдэнэ суман дахь МСҮТ				1				2	7.5	1		1	0.7
135	66	Увс аймаг дахь МСҮТ				1								1	6.9
136	67	Ховд аймаг дахь Хөгжил ПТК				1								2	81.1
137	68	Хэнтий аймаг дахь МСҮТ				1				1	0.9			1	
138	69	Хэнтий аймгийн Бор-Өндөр суман дахь МСҮТ				1									
139	70	Хөвсгөл аймаг дахь МСҮТ				1								4	14.6
140	71	Үйлдвэрлэл урлалын ПТК				1						1	96.5	2	0.1
141	72	Өвөрхангай аймаг дахь МСҮТ				1									
142	73	Өмнөговь аймаг дахь МСҮТ				1								3	86.6
143	74	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам				1				0		3	142.4	5	55.8

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

144	75	Ахмад настны асрамжийн үндэсний төв				1				1	9.8	1	43.2	4	7.0
145	76	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар					1			1	17.6	2	85.2	6	33.5
146	77	Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв	1												
147	78	Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр	1												
148	79	Өнөр бүл хүүхэд асран хүмүүжүүлэх төв				1				1	2.9	1	16.2	5	27.6
149	80	Мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээ мэдээллийн төв					1					3	54.8	4	245.0
150	81	Олон улсын хүүхдийн найрамдал цогцолбор				1				1	7.7	3	4.5	5	27.5
151	82	Сэргээн засалт сургалт үйлдвэрлэлийн төв				1						1		2	1.9
152	83	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар				1				1	0.5	1	7.2	1	5.8
153	84	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв					1					1	71.7	5	34.8
154	85	Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалтын үйлдвэр	1												
155	86	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт				1									
156	87	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв				1						1		3	9.0
157	88	Нийгмийн даатгалын сан татаас	1												
158	89	ХНХЯ. Хөрөнгө оруулалт, их засвар	1												
159	90	Их засварын чанарын баталгаа	1												
160	91	ХНХЯ-ны техник хяналт	1												
161	92	ХНХЯ. Барьцаа	1												
162	93	ХХҮЕГ-ын техник хяналт	1												
163	94	Сх. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв					1								
164	95	Бз. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв					1								
165	96	Да. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв					1							4	
		ДҮН	14	4	2	68	7	1		54	158	54	787	175	2,353
		НИЙТ	17	7	2	122	16	1		68	425.8	84	22,591.7	234	8,284.1

6. Төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ					
I.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын санхүүгийн нэгтгэсэн тайлан					
1	Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага Монгол-Солонгосын Политехник коллежийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар тус байгууллага нь кассаар хүлээн авсан өөрийн орлогыг төрийн сангийн бүртгэлийн дансанд төвлөрүүлээгүй, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, Засгийн газраас тогтоосон цалингийн сүлжээ, шатлалыг баримтлаагүйгээс цалин илүү олгосон, ажиллагсдын цалингаас суутгавал зохих НДШ, ХХОАТ-ыг дутуу суутгасныг байгууллагын төсвөөс төлсөн, урьдчилж орсон орлогыг данс буруу бүртгэснээс санхүүгийн тайланд орлого дутуу илэрхийлэгдсэн зэрэг зөрчил гаргасны улмаас “Сөрөг” санал дүгнэлт авсан.	-	Албан шаардлага	Монгол-Солонгосын политехник коллежийн захирал	Ц.Ганчимэг
ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ					
II.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар					
